

АЖ (ХҮНД) ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ:

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Нүүрс-хими, Кокс-химийн цогцолбор, Зэс боловсруулах цогцолбор, Гангийн цогцолбор, Газрын тос боловсруулах цогцолбор, алт цэвэршүүлэх үйлдвэрийг барьж байгуулан ашиглалтад оруулах 6 мега төсөл болон “Жоншны баяжмал боловсруулах цогцолбор, Барилгын материал үйлдвэрлэлийн цогцолбор зэрэг хүнд үйлдвэрүүдийг ашиглалтад оруулж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн боловсруулах төслүүд нь аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарт тэр дундаа хүнд үйлдвэрийн салбарт хэрэгжих төслүүд байна.

Олон улсын жишгийн дагуу тээвэр газарзүйн оновчтой байрлал, бүс нутгийн дэд бүтцийн хөгжил, түүхий эдийн нөөц хангамж, хүний нөөцийн чадавх, хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг харгалзан Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан аж үйлдвэржилтийн томоохон төсөл болох хүнд үйлдвэрийн цогцолборуудыг 12 байршилд үйлдвэрлэл, технологийн паркийн хэлбэрээр байгуулж хөгжүүлэхээр төлөвлөж Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6-д заасны дагуу “парк эрхлэх үйлдвэрлэлийн салбар, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүний төрөл, паркийн байршлын жагсаалт”-ыг Засгийн газрын 2024 оны 204 дүгээр тогтоолоор батлаад байна.

Төлөвлөөд байгаа 12 паркаас паркуудаас төрийн өмчит “Дархан” гангийн цогцолбор, “Эрдэнэт” зэс боловсруулах цогцолбор, “Тавантолгой” кокс химийн цогцолбор, “Багануур” нүүрс-химийн цогцолбор, “Бор-Өндөр” жонш, цахиур боловсруулах цогцолбор, “Хөтөл” барилгын материал үйлдвэрлэлийн цогцолбор, орон нутгийн өмчит “Налайхын үйлдвэрлэл, технологийн парк”, “Багахангай үйлдвэрлэл, технологийн парк”, хувийн өмчит “Дорнын баялаг” үйлдвэрлэл, технологийн паркууд нь паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар хөгжлийн төлөвлөгөө, нэгжийн техник эдийн засгийн үндэслэл, техник, технологийн түвшний үнэлгээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал зэрэг хуулиар шаардсан баримт бичгүүдийг бүрдүүлэн ажиллаж байгаа бол “Инфинити спейс” ХХК-ийн “Алтан ширээт”, “Си Өү Эй Эл” ХХК-ийн “Гэрэлт говь” үйлдвэрлэл, технологийн паркууд нь Засгийн газрын 2023 оны 267 дугаар тогтоолоор 15 жилийн хугацаатай олгосон үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч “Инфинитиспейс” ХХК-тай Засгийн газрын 2024 оны 191 дугаар тогтоолын дагуу, “Си Өү Эй Эл” ХХК-тай Засгийн газрын 2024 оны 85 дугаар тогтоолын дагуу тус тус “Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх” гурван талт гэрээг байгуулаад байна.

Тус гэрээний дагуу “Инфинитиспейс” ХХК-ийн “Алтанширээт” УТП болон “Си Өү Эй Эл” ХХК-ийн “Гэрэлт говь” УТП-ийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа нийт 2100 орчим нэр төрлийн бараа материалын 110 орчим тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар сунгаж, татвар төлөх хугацаа сунгасан хугацаанд паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэсэн 52.3 тэрбум төгрөгийн бараа материалын гаалийн албан татвараас чөлөөлөх боломж бүрдсэн нь УТП-ийн паркий үйл ажиллагаа эрхлэгчид төрөөс үзүүлэх татварын томоохон дэмжлэг болно гэж харж байна.

Аж үйлдвэрийг үйлдвэрлэл, технологийн паркийн хэлбэрээр хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ болон Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг Монгол Улсын Их Хурлын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн баталсан.

Дээрх хуулиуд батлагдсанаар Үйлдвэрлэл, технологийн паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч нь “Үйлдвэрлэл, технологийн паркийн зориулалтаар эзэмшиж, ашиглаж байгаа газрыг эхний 10 жилд газрын төлбөрөөс чөлөөлүүлэх, Үйлдвэрлэл, технологийн паркийн нутаг дэвсгэр дэх үл хөдлөх эд хөрөнгийг албан татвараас эхний 5 жилд чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлүүлэх, Үйлдвэрлэл, технологийн паркийн удирдлага, нэгжийн үндсэн хөрөнгө бий болгоход шаардагдах, дотоодын үйлдвэрлэлээс хангах боломжгүй импортоор оруулж байгаа барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийн гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацааг 4 жил хүртэлх хугацаагаар сунгаж, энэ хугацаанд өөрийн үндсэн хөрөнгөд бүртгэж үндсэн үйл ажиллагаандаа ашигласан барилгын материал, дэд бүтэц, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлүүлэх, Хөрөнгө оруулалтын тогтворжуулалтын гэрчилгээ, чөлөөт бүс,

үйлдвэрлэл, технологийн паркт үйл ажиллагаа явуулахад дэмжлэг үзүүлж, Засгийн газраас баталгаа гаргуулах, ажилчдыг сургаж, дадлагажуулах зорилгоор гадаадын иргэнийг ажлын байраар хангах, орлого бүхий ажил, үйлчилгээ үзүүлсэн бол ажлын байрны төлбөрөөс чөлөөлүүлэх зэрэг татварын болон татварын бус дэмжлэгийг авах боломжтой болсон.

Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд тус яамнаас санаачлан 5, хамтран 1 эрх зүйн баримт бичгийг боловсруулж, эрх бүхий байгуулагаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аж үйлдвэрийг үйлдвэрлэл, технологийн парк хэлбэрээр байгуулж, хөгжүүлснээр уул уурхайн гаралтай үйлдвэрлэлээс мэдлэг, нэмүү өртөг шингэсэн бүтээлч үйлдвэрлэлийн бүтцэд аажмаар шилжиж, экспортын чиг баримжаатай, импортыг орлох бүтээгдэхүүний тоо хэмжээ, нэр төрлийг нэмэгдүүлж, уул уурхайн хэт хамаарлыг багасгах, боловсруулах үйлдвэрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь хэмжээ, эдийн засгийн үр өгөөж, татварын орлого, бааз суурийг нэмэгдүүлэх, валютын ханшийг тогтворжуулах, орон нутагт ажлын байрыг олноор нэмэгдүүлж хот суурин газрыг чиглэсэн хүн амын хэт төвлөрлийг сааруулах зэрэг эдийн засаг, нийгмийн олон чухал ач холбогдолтой юм.